



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 4/210

Эрдэнэт

Г

Т

Улсын Онцгой комиссын
шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.5 “в”, 29.1.6 “л”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 31 дүгээр тушаал, 2021 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол эрчимтэй нэмэгдэж аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хариу арга хэмжээг авах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2. Дээрх хугацаанд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрсөн үйл ажиллагааг нэгдүгээр хавсралтаар, хязгаарласан үйл ажиллагааг хоёрдугаар хавсралтаар, аймгийн хэмжээнд хяналт тавьж ажиллах байгууллагуудын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Эрдэнэт хотын хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоон, хяналтыг эрчимжүүлж, эмнэлэг, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллага, хог тээвэрлэлтийн тээврийн хэрэгслийг дугаарын хязгаарлалтгүйгээр, бусад байгууллагуудын болон зайлшгүй шаардлагаар ажиллах ажилтан, албан хаагчдын хувийн тээврийн хэрэгсэл, нийтийн тээврийн хэрэгслийг өглөө 06.00-09.00, орой 17.00-21.00 цагийн хооронд зөвхөн гэр-ажил-гэр гэсэн маршрутын дагуу замын хөдөлгөөнд оролцуулан хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа С.Цэрэнсамбууд үүрэг болгосугай.

4. Аймгийн хэмжээнд гэр оронгүй, архины хамааралтай иргэд болон хараа хяналтгүй хүүхдүүдийн бүртгэл судалгааг тодотгох, хяналтад авах ажлыг зохион байгуулж, тэдэнд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (А.Наанболд), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний

газар (Х.Эрдэнэбат), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

5. Орхон аймаг, Эрдэнэт хотод орж, гарч, дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналт, ажлын зохион байгуулалтыг сайжруулж, албан ёсны хяналтын постоор орж ирээгүй зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг журамлах, жолооч, зорчигчдод холбогдох хариуцлага тооцох, тусгаарлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Тагнуулын газар (М.Очирбат), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Бат-Өлзий), Мал эмнэлгийн газар (П.Эрдэнэжаргал), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

6. Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын өрөө тасалгаа, байр, орон сууцны орц, хонгил, цонх, хаалга, цахилгаан шат, нийтийн тээврийн хэрэгслийн хаалга, суудал, бариул, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, хүүхдийн тоглоомын талбайн ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг үе шаттай зохион байгуулах, өдөр бүр ариутгал халдвартгүйтгэл хийж, халдварт хамгааллын дэглэмийг чанд сахиулахыг Эрдэнэт хотын Захирагчийн алба (С.Ганцогт), Хот тохижуулах газар (Б.Оюунбаяр), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа) нарт болон төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

7. Энэхүү захирамжийн гуравдугаар хавсралтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Мөнхбаяр), захирамж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр)-д үүрэг болгосугай.

8. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/151, А/167, А/179, А/181, А/186, А/196 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

9. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр ханган, тайлagnаж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.



Аймгийн Засаг даргын 2021 оны 04
дүгээр сарын 16.-ны өдрийн 16:10
Дугаар захирамжийн I хаворалт

ЗӨВШӨӨРӨГДСӨН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Эрчим хүч, дулаан, усан хангамж
2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага
3. Шүүх, өмгөөлөл, нотариат
4. Шатахуун, түлшний хангамж
5. Хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт
6. Ариутгал, халдвартгүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, тээвэрлэлт
7. Цахим банк, автомат тооцооны машин
8. Газар тариалан, өвс тэжээл, түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа
9. Харилцаа холбоо, шуудан илгээмж
10. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа /Шуурхай штабын зөвшөөрснөөр/
11. Хэвлэл мэдээлэл
12. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага
13. Геологи хайгуул, уул уурхай
14. Орон сууц, нийтийн үйлчилгээ, сууц өмчлөгчдийн холбоо
15. Буяны үйл ажиллагаа
16. Бүтээн байгуулалт, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл худалдаа /хүргэлт, түгээлтийн үйлчилгээ/
17. Иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор оршин суугаа газрын ойролцоо байршил, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайд алхах, дугуй унах, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх
18. Авто машины дугуй засвар

Аймгийн Засаг даргын 2021 оны 09
дүгээр сарын 16.-ны өдрийн 16/210
дугаар захирамжийн II хавсралт

ХЯЗГААРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгсэл, Баян-Өндөр, Жаргалант сумдын зорчих хөдөлгөөн
2. Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 08.00-20.00 хүртэл
3. Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа
4. Бага насны хүүхдийг асран хамгаалагчгүйгээр гадуур явуулах
5. Бүх төрлийн нийтийн хоолны заалны үйлчилгээ
6. Сургууль, цэцэрлэг, давтлага, спорт зааланд тоглох, сургалт, семинар, цугларалт, уншлага, хэлэлцүүлэг, РС тоглоом, фитнес, спиннинг, нийтийн бүжиг, амралтын газар, зочид буудал /дэн буудал хамаарах/-ын үйл ажиллагаа
7. Зах, худалдааны төвүүд /хүнс, бүх төрлийн бараа, тавилга, бэлэн хувцас/
8. Үйлчилгээний байгууллага /ломбард, үсчин, гоо сайхны бүх төрлийн үйлчилгээ, ахуйн үйлчилгээний салбар, цэгүүд/

ОО

Аймгийн Засаг даргын 2021 оны 04
дүгээр сарын 16-ны өдрийн 16:10
дугаар захирамжийн III хавсралт

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ

Д/Д	Багийн нэр	Хяналт хийх төрийн байгууллагууд
1	Зэст	<ul style="list-style-type: none"> - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар - Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
2	Оюут	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчин аялал жуулчлалын газар - Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар
3	Уурхайчин	<ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн хэлтэс - "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
4	Хүрэнбулаг	<ul style="list-style-type: none"> - Татварын хэлтэс - Номын төв
5	Бүрэнбүст	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуйн газар - Сэлэнгэ голын сав газрын захиргаа
6	Уртбулаг	<ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын Тамгын газар - Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ
7	Согоот	<ul style="list-style-type: none"> - Статистикийн хэлтэс - Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ
8	Наран	<ul style="list-style-type: none"> - Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар - Орхон АЗЗА ТӨХК
9	Их залуу	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар - Орон нутгийн өмчийн газар
10	Рашаант	<ul style="list-style-type: none"> - Стандарт хэмжил зүйн хэлтэс - Орхон мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв
11	Уртын гол	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын хэлтэс
12	Шанд	<ul style="list-style-type: none"> - Санхүү, хяналт, аудитын алба - Орхон аймаг дахь Төрийн аудитын газар
13	Дэнж	<ul style="list-style-type: none"> - Боловсрол, соёл урлагийн газар - Шуудан үйлчилгээний газар
14	Эрдэнэ	<ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - Шүүхийн шинжилгээний алба
15	Цагаанчулуут	<ul style="list-style-type: none"> - Биеийн тамир спортын газар - Нийтлэг үйлчилгээний алба
16	Баянцагаан	<ul style="list-style-type: none"> - Ус цаг уур, орчны шинжилгээний төв - Зэвсэгт хүчний 110 дугаар анги
17	Баянбулаг	<ul style="list-style-type: none"> - Мал эмнэлгийн газар - Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
18	Булаг	<ul style="list-style-type: none"> - Хот тохижуулах газар - Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК
19	Даваат	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, - Эрдэнэ Ус ДТС ОНӨХК
20	Говил	<ul style="list-style-type: none"> - Гаалийн газар - Зэвсэгт хүчний 186 дугаар анги
21	Яргүйт	<ul style="list-style-type: none"> - Хотын захирагчийн алба - Бүсийн оношилгоо эмчилгээний төв
22	Малчин	<ul style="list-style-type: none"> - Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар

23	Жаргалант сум	-Сумын Засаг даргын Тамгын газар
24	Нийтийн тээврийн үйлчилгээ	- Авто тээврийн төв
25	Төмөр зам	- Мэргэжлийн хяналтын газар

ХЯНАЛТ ТАВИХ ЧИГЛЭЛ:

1.Төрийн байгууллагын хяналт хийх албан хаагчид Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын "Түр журам батлах тухай" 2021 оны 18 дугаар тушаалыг уншиж танилцаж, мэдээллээр хангагдсан байх.

2.Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 18 дугаар тушаалыг багийн хэмжээнд байгууллага, иргэд, хуулийн этгээдэд ухуулан таниулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, зөрчлийг арилгуулах, зөвлөмжөөр ханган ажиллах

3.Халдварт хамгааллын дэглэм /амны хаалт зүүх, зайд барих, гар угаах.../-ийг баримтлуулах

4.Шаардлага биелүүлээгүй, ноцтой зөрчил илэрвэл холбогдох хяналтын улсын байцаагч наарт мэдэгдэх

5.Тухайн багийн Засаг дарга нар хөндлөнгийн хяналт хийж, мэдээллээр ханган дэмжиж ажиллах

6.Хяналтыг 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж, илтгэх хуудсыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст өгнө.

Тайлбар: Хяналт тавих байгууллагууд өдөр бүр 11.00-20.00 цагийн хооронд багуудын нутаг дэвсгэрт иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авч ажиллана.

ОО